



Европын Холбоо
санхүүгийн



Food and Agriculture
Organization of the
United Nations

НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлгөөний
Байгууллага



U
N
D
P



МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ,
СУРГАЛТЫН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, ИНДЕКС

ТАНИЛЦУУЛГА

БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН АНГИЛАЛ ГЭЖ ЙОУ ВЭ?

БОУСА нь боловсролын хөтөлбөр болон мэргэшлийг боловсролын түвшин (ISCED-2011), боловсролын чиглэл (ISCED-F-2013)-ээр ангилж улс орнуудын боловсролын тогтолцоог харьцуулах зорилготой, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ангилал, тодорхойлолт юм.

1976 (ISCED 1976)

1997 (ISCED 1997)

2011 (ISCED 2011)

2013 (SCED-F 2013)

Нэгдсэн Үндэстний
боловсрол,
шинжлэх ухаан,
соёлын байгууллага
(ЮНЕСКО) хүрээг
тодорхойлсон анхны
хувилбар.

Боловсролын
түвшин
тодорхойлолтыг
сайжруулсан.

Боловсролын түвшин
сургуулийн өмнөх
боловсрол (ISCED
0)-ос доктор (ISCED 8)
түвшин хүртэл ангилж,
боловсрол, сургалтын
үр дүнд түлхүү
анхаарсан.

Боловсролыг
судлагдахуунаар
ангилж
боловсролоор
олгож буй
мэргэшлийн
чиглэл, кодчиллыг
тодорхойлсон.

БОУСА НЭВТРҮҮЛЭХИЙН АЧ ХОЛБОГДОЛ



Бодлого, шийдвэр гаргана: Албан болон албан бус боловсрол, сургалтын тоо мэдээллийг стандартчилж өгнөөр улс, олон улсын түвшинд харьцуулан дүн шинжилгээ хийн бодлогын чиглэлийг тодорхойлох, нөөцийг хувиарлах;



Судалгаа, шинжилгээ хийнэ: Олон улсын түвшинд харьцуулж болохуйц тоо, мэдээлэл бий болсноор боловсролын салбарт судлаач, бодлого боловсруулагчид болон олон нийтийн оролцоо нэмэгдэнэ.



Боловсролын тогтолцоог илэрхийлнэ: Улс орон бүр БОУСА-д өөрийн орны харьцуулсан зураглал (ISCED-mapping) хийдэг ба үүнд, боловсролын түвшин бүрт хамрагдах шаардлага, нас, үргэлжлэх хугацаа, боловсролын баримт бичиг зэргийг тайлбарладаг тул тухайн орны боловсролын тогтолцооны талаар хэрэглэгчдэд илүү тодорхой ойлголт өгдөг.

МОНГОЛ УЛС МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРӨӨ БОУСА-Д НИЙЦҮҮЛСЭН ТАЛААР

Монгол Улсын хувьд БОУСА-ыг 2010-2022 онд дээд боловсролын хөтөлбөрт нэвтрүүлсэн. Улмаар 2022-2024 онд боловсролын хөтөлбөрийн нэг болох мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд нэвтрүүлэхтэй холбоотой дараах ажлуудыг хэрэгжүүлсэн.

2019

2022

2023

2024

Богино хугацааны сургалтын индексийг тодорхойлох судалгааны баг ХНХЯ-д ажилласан

Богино хугацааны сургалтын индексийг БОУСА-д нийцүүлэх аргачлал боловсруулах судалгааг НҮБХХ дэмжлэгтэй хийсэн

МТБС-аар бэлтгэх мэргэжлийн чиглэл индекс боловсруулах ажлын хээг 10 салбардаа ажилласан

БШУ-ы сайдын 2024.08.26 өдрийн А/49 тоот "Мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн чиглэл, индекс батлах тухай" тушаал батлагдсан. 2024 онд БШУ-ы сайдын 2024.10.01 өдрийн А/116 тоот тушаалаар А/49 тоот тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулсан.

МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, ИНДЕКСИЙН ГОЛ ШИНЭЧЛЭЛ

Боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED - БОУСА)-д нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл, индексийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 08 дугаар сарын 26 өдрийн А/49 тоот "Мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн чиглэл, индекс батлах тухай" тушаалаар баталсан.

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, ИНДЕКС

ISCED-F-2013					ISCED-2011	
Ерөнхий чиглэл	Төрөлжсөн чиглэл	Нарийвчилсан чиглэл	Индекс	Мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийн нэр	Боловсролын түвшин	
					3	4
10	25	60	168	Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц	Мэргэжлийн боловсрол III-IV	Техникийн боловсрол V-VI
					V	VI
					117	103
					144	

Олон улсын ангилал

Монгол улсын ангилал

*
Мэргэжлийн
сургалт
(Чадамхийн
нэгжээр
тодорхойлно)

(БОУСА)-ын 10 ерөнхий, 25 төрөлжсөн болон 60 нарийвчилсан чиглэлд нийцүүлэн Монгол улсын 168 мэргэжлийн чиглэлийг харгалзах А/116 тушаалаар хавсралтад орсон нэмэлт өөрчлөлтийг тусгахад мэргэжлийн хөтөлбөрүүдийг түвшингээр авч үзвэл:

Нийт 168 мэргэжлийн чиглэл

- Техникийн боловсролын V-VI түвшинд - 106
- Мэргэжлийн боловсролын III-IV түвшинд - 122
- Мэргэжлийн сургалт – 209

Ерөнхий чиглэлд хамаарах мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийн тоо

	Ерөнхий чиглэл	Мэргэжлийн чиглэл/ Хөтөлбөрийн тоо
01	Боловсрол	2
02	Урлаг, хүмүүнлэг	27
03	Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл сэтгүүл зүй	2
04	Бизнес, удирдлага, эрхзүй	6
05	Байгальн шинжлэх ухаан, математик, статистик	7
06	Мэдээлэл, харицаа холбооны технологиуд	7
07	Инженерчлэл, ўлдвэрлэл, барилга байгууламж	65
08	Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй	12
09	Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	10
10	Үйлчилгээ	30
Нийт		168

БАТЛАГДСАН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛ, ИНДЕКСИЙН ХЭРЭГЛЭЭ, ЗОРИУЛАЛТ

Судалгаа, шинжилгээ: Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон улсын түвшинд болон үндэсний хэмжээнд бусад боловсролын түвшинд харьцуулах, шилжилт, өөрчлөлтийг харах дүн шинжилгээ хийж болохуйц боловсролын статистик, үзүүлэлтүүдийг гаргах урьдчилсан нөхцөл.

Тусгай зөвшөөрөл: Сургалтын байгууллагуудад МбТБС эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох суурь баримт бичиг.

Хөтөлбөр боловсруулах: Мэргэжлийн чиглэл, индекс нь сургалтын хөтөлбөрийн ерөнхий хүрээ, агуулгыг тодорхойлоход ашиглана.

Хөдөлмөр эрхлэх баталгаа: Сургалтын хөтөлбөрийг хөрвөх чадвартай мэргэжилтэй ажилтан бэлтгэх уян хатан боловсруулах боломжийг олгож байна.

Боловсролын баримт бичиг: Төгсөгчийн боловсролын баримт бичигт эзэмшсэн мэргэжил, мэргэшлийн түвшинг тодорхойлоход хэрэглэдэг.

Насан туршийн боловсрол: Иргэн албан бус сургалтаар болон амьдралаас суралцаж эзэмшсэн ур чадвар, мэдлэгээ үнэлүүлэх, баталгаажуулах болон дээд боловсролын мэргэжлийн чиглэлтэй нийцүүлсэн тул шатлан суралцаад ойлгомжтой болсон.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдөх: Гадаад, дотоодод эзэмшсэн мэргэжил, боловсролын зэргийг олон улсад, олон улсад суралцаж эзэмшсэн боловсролын зэргийг Монгол Улсад хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэх боломжтой болно.

Үр ашигтай байдал: Хөтөлбөрийг чадамжийн нэгжээр багцалж боловсруулах, кодчилол бүхий сан үүсэгснээр хөтөлбөр боловсруулахад зарцуулдаг хөрөнгө, хүн хүч, цаг хугацаа хэмнэнэ.

ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ АЖИЛ

БОУСА-д шилжиж байгаа нь харьцуулах боломжтой мэдээлэл цуглуулах эхний алхам бөгөөд цаашид улс орон даяар түүштэй хэрэгжүүлэх явдал чухал гэж олон улсын байгууллагууд зөвлөж байна. Үүний тулд нэн тэргүүнд бид дараах ажлыг салбарын түншлэгчдийн оролцоотойгоор боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Үүнд:

- Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, үндэсний мэргэшлийн хүрээтэй уялдуулах
- Салбар тус бүрээр ажил мэргэжлийн стандарт, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн сан үүсгэх
- Мэргэжлийн чиглэл бүрт харгалзах мэргэшлийг тодорхойлж чадамжийн нэгжийг багцлан хөтөлбөр боловсруулах, багцлах дүрэм, кодлох аргазүйг тодорхойлох
- Түгээн дэлгэрүүлж, бүх салбарт нэвтрүүлэх.

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭХ СУРВАЛЖУУД

- Боловсролын ерөнхий хууль, 2023 он
- БШУ-ы сайдын 2024.01.11 өдрийн А/11 тоот “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тушаал
- International Standard Classification of Education ISCED-2011, UNESCO Institute for Statistics
- ISCED Fields of Education and Training 2013 (ISCED-F 2013), Manual to accompany the International

Standard Classification of Education 2011, UNESCO Institute for Statistics

- “Education indicators in focus” What are benefits of ISCED 2011 classification for indicators on education, OECD 2015
- International Standard Classification of Education (ISCED) Eurostat statistics explained, online publication
- OECD iLibrary: What are the benefits of ISCED 2011 classification for indicators on education?

ХОЛБОО БАРИХ:

Европын Холбооны санхүүжилттэйгээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Монгол улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төсөл



www.undp.org/mongolia



+976-11-327585